



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 55

Номгон

“Хонгор шинэ агро” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 123 дугаар тогтоолоор баталсан “Хонгор шинэ агро” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хонгор шинэ агро” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ц.Дашцэрэн-Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Т.Эрдэнэбат-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч

Ж.Баттөр-Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга


Т.Саранчимэг-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Жигжидсүрэн-Иргэний төлөөлөл

2. Үйлдвэрийн газрын дотоод журмыг холбогдох хуулийн дагуу баталж, компанийн эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР



1190063